



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 280

Улаанбаатар хот

「 Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 1,986,897,949.00 (нэг тэрбум есөн зуун наян зургаан сая найман зуун ерэн долоон мянга есөн зуун дөчин есөн) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Очирбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

130985084  
15-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 05 дугаар сарын 30 ны өдрийн  
д.д. Дугаар тогтоолын хаваралт

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн  
өмчид бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /тегрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Эмнэлгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо/	5 давхар, зоорьтой, нийт 1312.7м2	1,986,897,949.00	2022-06-16 УКД-БА-137/2022
	<b>Нийт дүн</b>		<b>1,986,897,949.00</b> <b>(нэг тэрбум есөн зуун</b> <b>наян зургаан сая найман</b> <b>зуун ерэн долоон мянга</b> <b>есөн зуун дөчин есөн)</b>	